



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/66/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот</p> <p>2021 он</p>	<p>Баянхонгор аймгийн Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:tseenyma@audit.gov.mn">tseenyma@audit.gov.mn</a> Аудитор: Г.Ганчимэг Утас: 88268424 Цахим хаяг: <a href="mailto:ganaa_7133@yahoo.com">ganaa_7133@yahoo.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайланТайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан .....	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3.Аудитын тайлан .....	12
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН БАЯН-ОЙТ Г  
БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.АЮУРЗАНА ТАНАА

2021.02.10. № 2/20  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Баян-Ойт бага сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын Баян-Ойт бага сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Баян-Ойт бага сургуулийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

2021 А4 ТООТ

005020882

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



**Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

**2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>90,198,488.70</u></b>	<b><u>85,021,789.69</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	59,391.00	10,009,391.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	59,391.00	10,009,391.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,950,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	59,391.00	59,391.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	90,139,097.70	75,012,398.69
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,987,631.00	4,371,953.00
35130	Эм боох материал	3,987,631.00	4,371,953.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	86,151,466.70	70,640,445.69
35410	Бичиг хэргийн материал	3,341,202.51	7,359,002.51
35420	Аж ахуйн материал	18,550,959.13	14,213,676.13
35440	Түлш, шатах тослох материал	1,100,587.22	587.22
35450	Барилгын засварын материал	5,523,005.00	10,396,005.00
35460	Хүнсний материал	3,599,170.01	321,565.01
35470	Бусад хангамжийн материал	54,036,542.83	38,349,609.82
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,098,221,552.77</u></b>	<b><u>2,088,578,365.05</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,098,221,552.77	2,088,578,365.05
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,098,062,052.69	2,088,578,365.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,044,215,473.00	2,053,020,473.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,052,613.41	-43,774,707.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,814,145.19	115,675,947.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	-66,214,502.21	-69,306,608.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,123,493.63	83,641,917.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	-66,416,325.67	-62,427,596.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	294,000.00	294,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-136,600.39	-150,600.43
39217	Ном	12,434,982.55	11,605,540.55
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	159,500.08	00.00
39301	Програм хангамж	319,000.00	00.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-159,499.92	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,188,420,041.47</u></b>	<b><u>2,173,600,154.74</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,830,455.00</u></b>	<b><u>4,400.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,830,455.00	4,400.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	3,830,455.00	4,400.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,593,708.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,236,747.00	4,400.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,236,747.00	4,400.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,184,589,586.47</u></b>	<b><u>2,173,595,754.74</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,184,589,586.47	2,173,595,754.74

**Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,225,483.90	52,225,483.90
51101	Өмч: - төрийн	52,225,483.90	52,225,483.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,048,227,428.57</b>	<b>2,037,233,596.84</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,048,227,428.57	2,048,227,428.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-10,993,831.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,136,674.00	84,136,674.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,188,420,041.47</b>	<b>2,173,600,154.74</b>

**2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,686,228,541.00</b>	<b>809,006,480.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,976,238,241.00</b>	<b>8,251,676.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,976,238,241.00</b>	<b>8,251,676.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,976,238,241.00	8,251,676.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,976,238,241.00	8,251,676.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>709,990,300.00</b>	<b>800,754,804.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	569,986,900.00	640,789,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>24,882,404.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	24,882,404.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>140,003,400.00</b>	<b>135,082,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	140,003,400.00	135,082,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>664,928,223.58</b>	<b>812,875,347.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>664,928,223.58</b>	<b>812,875,347.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>612,317,890.08</b>	<b>740,252,822.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>398,691,934.00</b>	<b>454,170,284.93</b>
210101	Үндсэн цалин	398,691,934.00	342,017,162.27
210102	Нэмэгдэл	00.00	51,636,127.87
210104	Урамшуулал	00.00	60,516,994.79
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,021,731.00</b>	<b>61,740,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,021,731.00	43,319,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	4,605,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	3,684,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	921,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	9,210,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>128,814,908.00</b>	<b>120,855,741.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,353,532.00	349,400.00
210302	Түлш, халаалт	112,000,000.00	114,691,005.00
210303	Цэвэр, бохир ус	7,461,376.00	5,815,336.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,560,510.20</b>	<b>43,596,265.82</b>

**Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	2,999,150.00	4,161,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,579,999.70	1,709,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,014,520.50	1,552,299.81
210404	Ном, хэвлэл	45,000.00	1,411,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,000.00	1,400,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,786,840.00	311,900.00
210408	Бараа материал акалсны зардал	00.00	33,049,916.01
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>80,896.00</b>	<b>2,687,618.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,896.00	2,687,618.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,414,545.00</b>	<b>1,902,950.00</b>
210604	Урсгал засвар	5,414,545.00	1,902,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,002,400.00</b>	<b>66,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,002,400.00	66,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>766,500.00</b>	<b>554,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	766,500.00	304,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,964,465.88</b>	<b>54,679,963.09</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	483,000.00	996,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,074,966.00	2,128,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,406,499.88	51,555,963.09
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,610,333.50</b>	<b>72,622,524.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,347,065.00</b>	<b>56,950,619.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,187,065.00	29,795,215.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,519,424.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,362,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,860,000.00	2,273,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>565,068.50</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	565,068.50	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,698,200.00</b>	<b>81,251.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,698,200.00	81,251.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>15,590,654.26</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	15,590,654.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,021,300,317.42</b>	<b>-3,868,867.10</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>7,124,964.63</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	7,124,964.63
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-7,124,964.63</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,021,300,317.42</b>	<b>-10,993,831.73</b>

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/төрөг/

*Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>709,990,300.00</b>	<b>800,754,804.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>709,990,300.00</b>	<b>800,754,804.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	569,986,900.00	640,789,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>24,882,404.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	24,882,404.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>140,003,400.00</b>	<b>135,082,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	140,003,400.00	135,082,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>709,990,300.00</b>	<b>762,838,240.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>709,990,300.00</b>	<b>762,838,240.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>655,066,981.50</b>	<b>693,493,320.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>394,438,418.00</b>	<b>456,402,631.93</b>
210101	Үндсэн цалин	312,444,000.00	344,249,509.25
210102	Нэмэгдэл	37,020,300.00	51,636,127.89
210104	Урамшуулал	44,974,118.00	60,516,994.79
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,038,500.00</b>	<b>61,740,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,631,900.00	43,319,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,601,600.00	4,605,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,881,300.00	3,684,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	720,300.00	921,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,203,400.00	9,210,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>127,221,200.00</b>	<b>122,449,449.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,353,532.00	349,400.00
210302	Түлш, халаалт	110,406,292.00	116,284,713.00
210303	Цэвэр, бохир ус	7,461,376.00	5,815,336.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,003,420.50</b>	<b>10,025,749.81</b>
210401	Бичиг хэрэг	2,239,850.00	1,962,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,580,000.00	609,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,014,520.50	1,552,299.81
210404	Ном, хэвлэл	2,271,200.00	910,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,000.00	1,400,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,762,850.00	3,592,250.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>8,655,177.00</b>	<b>6,556,940.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,605,177.00	3,671,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,050,000.00	2,885,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>41,942,000.00</b>	<b>7,403,550.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,882,000.00	680,000.00
210602	Тавилга	9,800,000.00	00.00
210604	Урсгал засвар	11,260,000.00	6,723,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,002,400.00</b>	<b>66,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,002,400.00	66,000.00

*Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>728,500.00</b>	<b>554,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	478,500.00	304,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,037,366.00</b>	<b>28,295,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,786,800.00	4,857,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,250,566.00	23,438,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,923,318.50</b>	<b>69,344,919.26</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>52,660,050.00</b>	<b>53,673,014.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,800,050.00	26,517,610.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,519,424.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,362,980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,860,000.00	2,273,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,698,200.00</b>	<b>81,251.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,698,200.00	81,251.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>565,068.50</b>	<b>15,590,654.26</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	565,068.50	15,590,654.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>37,916,564.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>37,916,564.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>37,916,564.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>37,916,564.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	37,916,564.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-37,916,564.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	00.00	208,661,254.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	72,299,096.87	00.00	208,661,254.77
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-2,771,797.23	00.00	-2,771,797.23
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,048,227,428.57	00.00	2,184,589,586.47
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,048,227,428.57	00.00	2,184,589,586.47
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,048,227,428.57	00.00	2,184,589,586.47
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,993,831.73	00.00	-10,993,831.73
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,225,483.90	84,136,674.00	2,037,233,596.84	00.00	2,173,595,754.74



2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	775,872,400.00	760,200,494.74
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	775,872,400.00	760,200,494.74
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	733,015,200.00	731,409,884.74
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	457,502,800.00	456,402,631.93
210101	Үндсэн цалин	344,700,700.00	344,249,509.25
210102	Нэмэгдэл	51,778,800.00	51,636,127.89
210104	Урамшуулал	61,023,300.00	60,516,994.79
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,740,000.00	61,740,000.00
210201	Тэтгэврийн даатгал	43,319,600.00	43,319,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,605,100.00	4,605,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,684,100.00	3,684,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	921,000.00	921,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,210,200.00	9,210,200.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	122,524,700.00	122,449,449.00
210301	Гэрэл, цахилгаан	349,900.00	349,400.00
210302	Түлш, халаалт	116,294,800.00	116,284,713.00
210303	Цэвэр, бохир ус	5,880,000.00	5,815,336.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,919,200.00	13,662,949.81
210401	Бичиг хэрэг	1,968,500.00	1,962,000.00
210402	Тээвэр, шатахуун	609,800.00	609,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,553,600.00	1,552,299.81
210404	Ном, хэвлэл	3,359,900.00	3,347,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,635,200.00	1,400,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,792,200.00	4,792,150.00
2105	<b>Норматив зардал</b>	6,561,100.00	6,556,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,672,400.00	3,671,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,888,700.00	2,885,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	38,849,900.00	38,778,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,250,000.00	23,250,000.00
210604	Урсгал засвар	15,599,900.00	15,528,550.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	66,000.00	66,000.00
210702	Дотоод албан томилолт	66,000.00	66,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	591,400.00	554,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	341,400.00	304,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	31260100.00	31199364.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,461,600.00	7,456,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,798,500.00	23,742,464.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	42857200.00	28790610.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	42,857,200.00	28,790,610.00

*Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,576,900.00	26,517,610.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,280,300.00	2,273,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	775,872,400.00	760,200,494.74
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	640,789,700.00	625,199,045.74
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	640,789,700.00	625,199,045.74
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	135,082,700.00	135,001,449.00
132001	Орон нутгийн төсвөөс	135,082,700.00	135,001,449.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	01	01
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01	01
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	39	39
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22
620003	Үйлчлэх ажилтан	16	16
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	596	560
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	596	560
630001	Төрийн өмчит ЕБС	596	560
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	39	39
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	23	23
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16

**2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан:**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>24,882,404.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>24,882,404.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		24,882,404.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	24882404.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		24,882,404.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		16,519,424.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,632,980.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	24882404.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		24,882,404.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,882,404.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Л.Аюурзана танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав

Аудитыг 2021.02.07-ноос 2021.02.09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.10.28-ний өдрийн 64 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна

#### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургууль нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

- Багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх ажлыг хэвшүүлж багшийн хөгжлийн төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах.
- “Сайн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, ЗАН, секц, багаараа хамтран нээлттэй, судалгаат, хамтын, зочинтой хичээлүүдийг явуулдаг менежментийг сургууль, цэцэрлэг бүр хэрэгжүүлэх.
- Цэцэрлэг болон сургуулийн нийт сурагчдыг хамруулан хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдын олон талт оюуны чадамжийг хөгжүүлэх зорилгоор математик сэтгэлгээг хөгжүүлэх нэмэлт сургалт, болон англи хэлний сургалтыг цэцэрлэг, сургуулийн наснаас нь сургах туршилтыг чанартай зохион байгуулна.
- Багшийн ажлыг мэдлэг, ур чадвар, сурган хүмүүжүүлэх үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр үнэлж урамшуулдаг болох.
- “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлж, сургалтын байгууллага ёс зүйн зөрчлөөс ангид байхыг эрхэмлэн багш, ажилтан бүр ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа чанд мөрдөнө.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 1,2,3 дугаар улирлын шилэн дансанд аудит хийж аудитаар зөрчил илрээгүй байна.

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 502167,1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10043,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 820000,3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16400,0 мянган төгрөгөөр материаллаг байдлын суурийн дахин тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14819,9 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	90,198.5	85,021.8	(5,176.7)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	59.4	10,009.4	9,950.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	90,139.1	75,012.4	(15,126.7)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,098,221.6	2,088,578.4	(9,643.2)
Үндсэн хөрөнгө	2,234,201.1	2,264,237.9	30,036.8
Хуримтлагдсан элэгдэл	(135,979.5)	(175,659.5)	(39,680.0)
<b>Нийт хөрөнгө</b>	2,188,420.0	2,173,600.2	(14,819.9)
Өр төлбөр	3,830.5	4.4	(3,826.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,184,589.6	2,173,595.8	(10,993.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	2,188,420.0	2,173,600.2	(14,819.9)

Эх сурвалжийг/ Санхүүгийн тайлангаас авав/

Авлага дансны үлдэгдэл 10009,4 мянган төгрөг болж 9950,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны эцэст сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар “Санко Маркетинг Монголиа” ХХК-аас “Ухаалаг самбар” худалдан авахаар мөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75012,3 мянган төгрөг болж 15126,7 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуй материалын данснаас 11257,4 мянга, бусад хангамжийн материалын данснаас 21792,4 мянган төгрөгийн цаашид ашиглагдахгүй бараа материалыг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2264237,8 мянган төгрөг болж 30036,7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 38396,5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном худалдаж авсан, бараа материалын данснаас 2599,5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн бүртгэсэн, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 7041,6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 07 сарын 31 ний өдрийн 49 дугаар тогтоолоор 19000,9 мянган төгрөгийн акталсан үндсэн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 319,0 мянган төгрөгөөр буурсан ашиглалтгүй байгаа программ хангамжийг данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,4 мянган төгрөг болж 3826,0 мянган төгрөгөөр буурсан өмнөх оны өр төлбөрийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2173595,7 мянган төгрөг болж 10993,8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн 10993,8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 809006,4 мянган төгрөг болж өмнөх оноос 1877222,0 мянган төгрөгөөр буюу 69,8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 1877222,0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь тусгай зориулалтын санхүүжилт 70802,8 мянга төгрөгөөр нэмэгдсэн урсгал үйл ажиллагааны санхүүжилт 4920,7 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1967986,5 мянган төгрөгөөр буурсан нэмэлт санхүүжилтийн орлого 24882,4 мянган төгрөгөөр нэмэгдсэн зэрэг өөрчлөлтүүд гарсан байна.

Нийт зардал 812875,3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 147947,1 мянган төгрөгөөр буюу 22,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, хангамжийн материалын зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 828631,1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 858631,1 мянган төгрөгөөр тооцон, суралцагчдын тоог 593, ажиллагсдыг 39 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25861,8 мянган төгрөгөөр бууруулж 802769,3 мянган төгрөгөөр, суралцагчдын тоог 675, ажиллагсдыг 39 орон баталсан байна. Гэрэл цахилгаан, тавилга, урсгал засварын зардлыг бууруулан баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 802769,3 мянган төгрөгийг батлагдсанаас 3 удаагийн зохицуулалт хийж 26896,9 мянган төгрөгөөр хасаж 775872,4 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 640789,7 мянга, орон нутгийн төсвөөс 135082,7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 640789,7 мянган, орон нутгийн төсвөөс 135082,7 мянган төгрөгийн нийт 775872,4 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж 15671,9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 760200,4 мянган төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 1100,1 мянга, тогтмол зардал 75,2 мянга, хангамжийн материал 256,2 мянга төрөөс иргэдэд олгох бусад тэтгэмж, урамшуулал 14066,5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 15671,9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний зардлыг 15671,9 мянган төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

*Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Энэ нь “Ковид-19” цар тахлаас шалтгаалж сургуулийн үйл ажиллагааг түр хязгаарлалт хийсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр зориулалтаар

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ХӨТӨЛБӨР 71802</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 80109</b>				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	556,597,800.00	549,278,710.81	7,319,089.19	98.69
УРСГАЛ ЗАРДАЛ	556,597,800.00	549,278,710.81	7,319,089.19	98.69
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	556,597,800.00	549,278,710.81	7,319,089.19	98.69
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил			0.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл			0.00	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,524,700.00	122,449,449.00	75,251.00	99.94
<b>ХӨТӨЛБӨР 71802</b>			0.00	
<b>АРГА ХЭМЖЭЭ 81801</b>			0.00	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,576,900.00	26,517,610.00	14,059,290.00	65.35
УРСГАЛ ЗАРДАЛ	40,576,900.00	26,517,610.00	14,059,290.00	65.35
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,576,900.00	26,517,610.00	14,059,290.00	65.35
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж дэмжлэг	40,576,900.00	26,517,610.00	14,059,290.00	65.35
<b>ХӨТӨЛБӨР 71802</b>			0.00	
<b>АРГА ХЭМЖЭЭ 80802</b>			0.00	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,280,300.00	2,273,000.00	7,300.00	99.68
УРСГАЛ ЗАРДАЛ	2,280,300.00	2,273,000.00	7,300.00	99.68
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,280,300.00	2,273,000.00	7,300.00	99.68
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,280,300.00	2,273,000.00	7,300.00	99.68
<b>ХӨТӨЛБӨР 71802</b>			0.00	
<b>АРГА ХЭМЖЭЭ 81834</b>			0.00	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	391,215,900.00	398,038,651.81	-6,822,751.81	101.74
УРСГАЛ ЗАРДАЛ	391,215,900.00	398,038,651.81	-6,822,751.81	101.74
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,215,900.00	398,038,651.81	-6,822,751.81	101.74
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	285,239,800.00	292,115,648.00	-6,875,848.00	102.41
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39831400	39831400	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал	11374200	11438749.81	-64,549.81	100.57
Норматив зардал	6561100	6556940	4,160.00	99.94
Эд хогшил, урсгал засварын зардал	26291900	26226550	65,350.00	99.75
Томилолт, зочны зардал	66000	66000	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	591400	554000	37,400.00	93.68
Бараа үйлчилгээний бусад зардал	21260100	21249364	10,736.00	99.95
<b>ХӨТӨЛБӨР 71802</b>				
<b>АРГА ХЭМЖЭЭ 81835</b>				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206716600	198369783.9	8346816.07	95.96
УРСГАЛ ЗАРДАЛ	206716600	198369783.9	8346816.07	95.96
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206716600	198369783.9	8346816.07	95.96
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	172263000	164286983.9	7976016.07	95.37
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21908600	21908600	0	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал			0	
Хангамж, бараа материалын зардал	2545000	2224200	320800	87.39
Бараа үйлчилгээний бусад зардал	10000000	9950000	50000	99.50

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 24882,4 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан.

Үүнээс Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 16519,4 мянга, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 8632,9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Шилэн дансны тухай” хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 10 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 43640,1 мянга, зарлагын 16885,8 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 49924,8 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт-3

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	0	2
2	Хагас жил	4	4	4	0		
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	36	0		
5	Тухай бүр	8	96	87	9		
6	Нийт	27	151	139	10	0	2

Эх сурвалжийг/ байгууллагын шилэн данснаас авав/

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 11173,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

Хүснэгт-4

/Мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	11173,0	2	11173,0			
Нийт дүн	2	11173,0	2	11173,0			

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18186,0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2599,5 мянган төгрөгийн алдааг залруулж, 5577,2 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 10009,3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Бараа материалын дансанд бүртгэлтэй 7 нэр төрлийн 2599,5 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн тайланг залруулав.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 15586,5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5577,2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож хүргүүлээ. Үүнд:

1. Сургуулийн нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 749.0 мянган төгрөгөөр цэцэрлэгийн үйлчилгээний 7 ажилтанд нормын хувцас хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38. "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"-гэсэн заалт зөрчсөн байна.

#### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлан онд 650 хүүхэд, нийт 26656 хүүхэд өдөрт 24726,7 мянган төгрөгийг зарцуулж үдийн цай хөтөлбөрийн зардлаас 11 сард 4059 хүүхэд өдөрт нэг хүүхдэд 1275 төгрөгөөр олгож төсвийг 1522.1 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2019.12.18 ний "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоолын 3. "Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 900 (есөн зуун) төгрөгөөр, ерөнхий боловсролын тусгай сургуулийн нэг хүүхдийн үдийн хоолны зардлыг 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр тус тус тогтоосугай". гэсэн заалтыг зөрчсөн.

#### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Сургуулийн захирлын 2020.12.14 ний өдрийн А/31, А/32 тоот тушаалаар 38 албан хаагчид 1814 илүү цагийн хөлсөнд 10965,8 мянган төгрөгийн цалинг олгосон Үүнээс сургалтын менежерээр илүү цагийн тооцоо гаргуулаагүй 16 багшид 628 цагийн хөлсөнд 4150,8 мянган төгрөгийг илүү олгосон ба НДШ, ХХОАТ-ыг хасаж тооцоход 3306,1 мянган төгрөгийг цалин олгож цалингийн зардлаас 3648,6 мянган төгрөгийг НДШ-ын зардлаас гүйлгэн зарцуулж төсөв хэтрүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4. "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

#### Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 10009,3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

**3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал *данстай холбоотой асуудал*

**1.1 Илрүүлэлт:** "Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, өмнөх оны 59,3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалттай нийцэхгүй байна.

**1.2 Эрсдэл:** Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

**1.3 Өгсөн зөвлөмж:** Өмнөх оны авлагыг барагдуулах, нийлүүлэгч ААНБ-аас хөрөнгийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, Цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллах, "Ковид-19" цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашиггүй зарцуулахгүй байж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## 2. Удирдлагын дээд болон дотоод хяналт:

**2.1 Илрүүлэлт:** Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 10 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 43640,1 мянга, зарлагын 16885,8 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 49924,8 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.2 Эрсдэл:** Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

**2.3 Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: 2020.12.31	Аудитын нэр:	<b>2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: БНА-2021/66/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор сумын Баян-Ойт цогцолбор сургуулийн		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Сургуулийн төсөвт оны эцэст зохицуулалт хийлгэж "Санко Маркетинг Монголиа" ХХК-аас сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэсэн, өмнөх оны авлага 59.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалтыг зөрчсөн байна.	10009.3	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
2	Сургуулийн нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 749.0 мянган төгрөгөөр цэцэрлэгийн үйлчилгээний 7 ажилтанд нормын хувцас хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан	749.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
3	Үдийн цай хөтөлбөрийн зардлаас 11 сард 4059 хүүхэд өдөрт нэг хүүхэдэд 1275 төгрөгөөр олгож төсвийг 1522.1 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.	1522.1	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
4	Тайлант хугацаанд "Шилэн дансны тухай" хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 10 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 43640,1 мянга, зарлагын 16885,8 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 49924,8 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
5	Сургуулийн захирлын 2020.12.14 ний өдрийн А/31, А/32 тоот тушаалаар 38 албан хаагчид 1814 илүү цагийн хөлсөнд 10965,8 мянган төгрөгийн цалинг олгосон Үүнээс сургалтын менежерээр илүү цагийн тооцоо гаргуулаагүй 16 багшид 628 цагийн хөлсөнд 4150,8 мянган төгрөгийг илүү олгосон ба НДШ, ХХОАТ-ыг хасаж тооцоход 3306,1 мянган төгрөгийг цалин олгож цалингийн зардлаас 3648,6 мянган төгрөгийг НДШ-ын зардлаас гүйлгэн зарцуулж төсөв хэтрүүлж зарцуулсан байна.	3306.1	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
6	Бараа материалын дансанд бүртгэлтэй 7 нэр төрлийн 2599.5 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн санхүүгийн тайланг залруулав.	2599.5	Залруулга хийсэн	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Л.Аюурзана, Ж.Амаржаргал
<b>ДҮН</b>		<b>18186.0</b>			

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ГАНЧИМЭГ 2021.02.10

А.ЦЭЭНЯМ 2021.02.10

Б.МӨНХБАТ 2021.02.10

